# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 48 (381)

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Улсын Их Хурлын даргын ажлын хэсгийн орон тоог батлах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2004 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний тодотгосон жагсаалтыг батлах тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар**
**Улаанбаатар хот**
**2004 он**

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот 2004 оны арванхоёрдугаар сарын 31 №48 (381)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

| | | | |
|---|---|---|---|
| 472. | Онцгой албан татварын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай | | 884 |
| 473. | Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 884 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 474. | Ерөнхийлөгч Н. Багабандийн бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсны дараа олгох орон сууцны тухай | Дугаар 35 | 884 |
| 475. | Улсын Их Хурлын даргын ажлын хэсгийн орон тоог батлах тухай | Дугаар 36 | 884 |
| 476. | Ерөнхийлөгчийн хоригийн тухай | Дугаар 37 | 885 |

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | | |
|---|---|---|---|
| 477. | Отгоны Пүрэвт Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай | Дугаар 190 | 885 |
| 478. | Гэнэнгийн Батбаярт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай | Дугаар 191 | 885 |
| 479. | Усны-Эхийн Далантайд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай | Дугаар 192 | 886 |
| 480. | Балдандоржийн Туяад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай | Дугаар 193 | 886 |
| 481. | Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 194 | 886 |
| 482. | Жанцангийн Батчулуунд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 195 | 886 |

### Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 483. | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2004 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний тодотгосон жагсаалтыг батлах тухай | Дугаар 229 | 889 |
| 484. | Зарим хүнийг ажлаас чөлөөлөх тухай | Дугаар 232 | 898 |
| 485. | Зарим хүнийг ажилд томилох тухай | Дугаар 233 | 898 |
| 486. | Журамд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 235 | 898 |

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2004 оны 12 дугаар сарын 24-ний өдөр** | **Улаанбаатар хот**

### ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2004 оны 12 дугаар сарын 2-ны өдөр батлагдсан Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн "2" гэсний "эх орны үйлдвэрийн 40 хүртэл хатуулагтай архины литр тутамд 4; 40 ба түүнээс дээш хатуулагтай архины литр тутам 6; бүх төрлийн дарсны литр тутамд 1 ам.доллар" гэсэн хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн заалттай холбогдуулан эх орны үйлдвэрийн архинд онцгой албан татвар шингэсэн үнэлгээнээс 80 хувиар, бүх төрлийн дарсанд 30 хувиар тус тус тооцон онцгой албан татвар ногдуулж байсугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2004 оны 12 дугаар сарын 24-ний өдөр** | **Улаанбаатар хот**

### ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28.3-ын "зургаан сарын дотор" гэснийг "арван найман сарын дотор" гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2004 оны 12 дугаар сарын 16-ны өдөр** | **Дугаар 35** | **Улаанбаатар хот**

### Ерөнхийлөгч Н.Багабандийн бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсны дараа олгох орон сууцны тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Ерөнхийлөгч Н.Багабандийн бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсны дараа суух орон сууцыг улсын зардлаар барьж, өөрийнх нь өмчлөлд шилжүүлэн өгөхийг Монгол Улсын Засгийн газар /Ц.Элбэгдорж/-т даалгасугай.

2.Ерөнхийлөгч Н.Багабандийн бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсны дараа суух орох сууц барихад дэмжлэг үзүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ц.Элбэгдорж/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2004 оны 12 дугаар сарын 16-ны өдөр** | **Дугаар 36** | **Улаанбаатар хот**

### Улсын Их Хурлын даргын ажлын хэсгийн орон тоог батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 35.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын даргын ажлын хэсгийн орон тоог хавсралтаар баталсугай.

2.Улсын Их Хурлын даргын ажлын хэсгийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг зохих журмын дагуу шийдвэрлүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газар /Н.Лувсанжав/-т даалгасугай.

3.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР**

*Улсын Их Хурлын 2004 оны*
*36 дугаар тогтоолын хавсралт*

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН АЖЛЫН**
**ХЭСГИЙН ОРОН ТОО**

| № | Албан тушаал | Орон тоо |
|---|---|---|
| 1. | Улс төрийн бодлогын зөвлөх (Ажлын хэсгийн ахлагч) | 1 |
| 2. | Хууль зүйн бодлогын зөвлөх | 1 |
| 3. | Эдийн засаг, нийгмийн бодлогын зөвлөх | 1 |
| 4. | Олон нийт, хэвлэл мэдээллийн асуудал эрхэлсэн зөвлөх | 1 |
| 5. | Шадар туслах | 1 |
| 6. | Зохион байгуулагч | 1 |
| | Нийт | 6 |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2004 оны 12 дугаар сарын 24-ний өдөр** **Дугаар 37** **Улаанбаатар хот**

**Ерөнхийлөгчийн хоригийн тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 14.3-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурал 2004 оны 12 дугаар сарын 2-ны өдөр баталсан Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим заалтад Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тавьсан хоригийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2004 оны 12 дугаар сарын 28-ны өдөр** **Дугаар 190** **Улаанбаатар хот**

**Отгоны Пүрэвт Монгол Улсын шинжлэх**
**ухааны гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Боловсрол, шинжлэх ухааны байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж манай оронд түүхэн газар зүйн ухааныг хөгжүүлэх, угсаатны болон бөө судпал, нийслэлийн үүсч хөгжсөн түүхийн талаар бүтээлүүд туурвиж монголын уламжлалт соёл, ёс заншлыг хойч үеийнхэнд сурталчлан өвлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Отгоны Пүрэвт Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2004 оны 12 дугаар сарын 28-ны өдөр** **Дугаар 191** **Улаанбаатар хот**

**Гэнэнгийн Батбаярт Монгол Улсын**
**гавъяат жүжигчин цол хүртээх тухай**

Мэргэжлийн урлагийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж, зохиолын болон ардын олон арван дууг чадварлаг дуулж, дуулах урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Цэргийн дуу, бүжгийн эрдмийн чуулгын гоцлол дуучин Гэнэнгийн Батбаярт Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 12 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 192 | Улаанбаатар хот

### Усны-Эхийн Далантайд Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад үр бүтээлтэй ажиллан дэлхийн сонгодог болон үндэсний олон дуурь, ардын, зохиолын дуу, ари романсыг гоцлон чадварлаг дуулж, мэргэжлийн дуулаачдын олон улсын уралдаануудад оролцон тэргүүн байруудад шалгарч урлагийн ертөнцөд улс орныхоо нэр төрийг өргөн мандуулсан амжилтыг нь үнэлж Улсын дуурь, бүжгийн эрдмийн театрын гоцлол дуучин Усны-Эхийн Далантайд Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 12 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 193 | Улаанбаатар хот

### Балдандоржийн Туяад Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээх тухай

Урлагийн байгууллагад үр бүтээлтэй ажиллан монголын хошин урлагийн театрыг үүсгэн байгуулалцаж, үзэгчдийн таашаалд нийцсэн жүжиг, киноны олон гол, туслах дүрийг чадварлаг бүтээж, хошин урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж жүжигчин Балдандоржийн Туяад Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 12 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 194 | Улаанбаатар хот

### Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай

Боловсрол, эрүүл мэнд, ус, цаг уур, газрын харилцаа, геодези, зураг зүй, радио, статистик, батлан хамгаалах, даатгал, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил идэвх санаачилга үр бүтээлтэй, ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай .

#### ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Юндэнгийн Дашбал- Монголын ноос, ноолуурын холбооны болон "Монгол нэхмэл" ХК-ийн зөвлөх
2. Тангадын Намсрай - БХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн, бэлтгэл хурандаа

#### ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

Пунцагийн Пүрэвбазар- ЗХЖШ-ын Холбоо, цэргийн удирдлагыг автоматжуулах хэлтсийн дарга, хурандаа

**"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:**

1. Ундгайн Арвинбуян-Иргэний нисэхийн ерөнхий газрын нислэгийн хяналтын хэлтсийн дарга

2. Дамбын Баатархүү-МУИС-ийн Цөмийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

3. Төвдийн Бадхаа-П.Н.Шастины нэрэмжит Клиникийн төв эмнэлгийн рентген-оношлогооны тасгийн эрхлэгч

4. Чойжилын Батсүрэн-Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн монгол хэлний багш

5. Дүгэрсүрэнгийн Билэгт-Монголын энх тайван найрамдлын байгууллагуудын холбооны ерөнхий захирал

6. Дагдандоржийн Бэгзжав-Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 15 дугаар хорооны өндөр настан, ахмад тэтгэврийн

7. Лочинсүрэнгийн Готовдорж- Нийслэлийн үйлдвэрлэл,худалдаа, үйлчилгээний"Ган зуух" ХХК-ийн зохион бүтээгч

8. Цэндсүрэнгийн Гунгаанямбуу-Нийслэлийн санхүү бүртгэлийн "НИММ Аудит" ХХК-ийн ерөнхий захирал

9. Цэгмидийн Дамдинсүрэн-ШУА-ийн "Эрдэм" сонины гэрэл зургийн сурвалжлагч

10. Дагвадоржийн Долгормаа-Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дэд дарга

11. Дорждамбын Дорждэрэм-Төв аймгийн Зуунмод сумын Нацагдорж багийн иргэн, өндөр настан

12. Цэрэндоржийн Дугар-"Үнэн" сонины зар сурталчилгааны албаны ажилтан

13. Балдангийн Дэмбэрэл-Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын мэргэжилтэн

14. Сүрэнжавын Жадамба-Геологи хайгуул, олборлолт, худалдааны "Цэвдэг" ХХК-ийн ерөнхий зөвлөх, уурхайн дарга

15. Өлзийн Жамбал-Завхан аймгийн Ургамал сумын Тосгуур багийн малчин

16. Вангаагийн Идэш-Ховд аймгийн Мөнххайрхан сумын ЗДТГ-ын дарга

17. Дүгэрийн Лхагваа-Нийслэлийн холбоо, үйлдвэрлэл, үйлчилгээний "Мандваа" ЗБН/зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл/-ийн инженер

18. Гомбодоржийн Лхагвасүрэн-Булган аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал

19. Пагчигийн Лхагвасүрэн-МУБИС-ийн Дэлхийн түүхийн тэнхмийн эрхлэгч

20. Доржпаламын Маналжав-Төр, засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын барилга хөрөнгө оруулалт, байр ашиглалтын хэлтсийн дарга

21. Лхагважавын Мягмаржав-Нийслэлийн хүнсний үйлдвэрлэлийн "Талх чихэр" ХК-ийн ахлах эдийн засагч

22. Түмэнбаярын Нямдорж-Монголын хувиараа аж ахуй эрхлэгчдийн холбооны ерөнхийлөгч

23. Жүгдэрхорлоогийн Оюун-Нийслэлийн Ажилчин залуучуудын ээлжийн сургуулийн биологийн багш

24. Цэрэнцолын Оюун-МУБИС-ийн Монгол судлалын сургуулийн монгол хэлний шинжлэлийн тэнхмийн багш

25. Пүрэвжавын Өлзийбат-Дундговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал

26. Жигмэддоржийн Пүрэвдорж-Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал

27. Цэрэнсономын Сандаг-Очир-Архангай аймгийн Хөгжимт драмын театрын гоцлол дуучин

28. Биньеэгийн Сүрэнжав-Нийслэлийн Баянзүрх дүүргийн 59 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч

29. Туваанжавын Төмөрбаатар-Радио нэвтрүүлэх станцын хангамжийн инженер

30. Гүнбэлийн Тэрбиш-Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 5 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

31. Рэндоогийн Уртнасан-СУИС-ийн тайзны ярианы тэнхмийн эрхлэгч

32. Авирмэдийн Хатантөмөр-Дундговь аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний төвийн дарга

33. Хайнзангийн Цэгмид-Монголын урчуудын эвлэлийн хорооны бие даасан уран бүтээлч, баримлач

34. Дондогийн Цэдэв-Улсын мэргэжлийн хяналтын газрын авто замын хяналтын улсын байцаагч

35. Базарраднаагийн Цэдэндорж-Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Илч импекс" ХХК-ийн ерөнхий захирал

36. Пүрэвийн Цэрэндулам-Нийслэлийн Баянзүрх дүүргийн 84 дүгээр дунд сургуулийн захирал

37. Лувсанцэрэнгийн Чанцал-"Монгол даатгал" компанийн Сонгинохайрхан салбарын менежер

38. Балжиннямын Чимэд-Очир- МУБИС-ийн Магадлалын онол, математик, статистикийн тэнхмийн багш

**ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:**

Гомбын Баярсайхан- БХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн, дэд хурандаа

**ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Лувсанцэрэнгийн Алтанцэцэг-Нийслэлийн барилга үйлдвэрлэлийн "Эрэл барилга" ХХК-ийн эдийн засагч, нярав

2. Цэвээний Бадам-Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын Кадастрын хэлтсийн мэргэжилтэн

3. Загдын Батаа-Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын хэмжил зүйн лабораторийн эрхлэгч

4. Дамдинжавын Батжаргал-Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Америк, Их Британи судлалын тэнхмийн багш

5. Пүрэвийн Баттунгалаг-Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасгийн их эмч

6. Гомбосүрэнгийн Баянбат-Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн ерөнхий санхүүч

7. Жамбалдоржийн Биндэръяа-Төв аймгийн Баянчандмань сум дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн арга зүйч багш

8. Горчинсүрэнгийн Бямбаа-Сүхбаатар аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн ахлах эдийн засагч

9. Лувсанбалдангийн Бямбасүрэн-Нийслэлийн худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний "Эрэл" ХХК-ийн Тоосгоны үйлдвэрийн эрлэгчин

10. Чимэдийн Гаадамба-Төв аймгийн Баянчандмань сум дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн онолын багш

11. Төвхөөгийн Гансүх-Улаанбаатар хотын төв номын сангийн 1 дүгээр салбарын номын санч

12. Чүлтэмийн Гомбосүрэн-Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга

13. Рэнцэнгийн Дарьхүү-Хүнсний технологийн коллежийн дэд захирал

14. Нацагийн Дашлэгцэгмаа-Төв аймгийн Музейн захирал

15. Мөнгөний Долгор-Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын ахлах нягтлан бодогч

16. Доржхорлоогийн Долгорсүрэн-УБТЗ-ын Санхүүгийн хэлтсийн дарга

17. Бадарчийн Должинсүрэн-Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 16 дугаар цэцэрлэгийн дуу хөгжмийн багш

18. Чирчингийн Дорждэрэм - Барилга үйлдвэрлэлийн "Бридж констракшн" ХХК-ийн гүйцэтгэх захирал

19. Цэрэнгийн Жалцав-Ховд аймгийн ЗДТГ-ын Стратегийн төлөвлөлт, бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн орлогч дарга

20. Доржготовын Мөнхбаатар-Барилга, хот байгуулалтын яамны Газрын харилцаа, эрхийн улсын бүртгэлийн бодлого, зохицуулалтын газрын дарга

21. Халтарын Мөнхцогт-Хэнтий аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн технологийн багш

22. Бямбын Мягмарсүрэн-Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Нийгмийн халамж үйлчилгээний төвийн тэтгэврийн байцаагч

23. Цэгмидийн Мягмарсүрэн-Булган аймгийн Ус цаг уурын орчны шинжилгээний төвийн техникч

24. Очирбатын Намсрай-Нийслэлийн нийтийн зорчигч тээврийн "Автобус-1" компанийн жолооч

25. Хусаалайн Нинлай-Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээний компанийн нягтлан бодогч

26. Дорлигжавын Нүрзэд-Завхан аймгийн Ургамал сумын 8 жилийн дунд сургуулийн газарзүйн багш

27. Бадарчингийн Оюунчимэг-Улсын мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч

28. Жамбалын Оюунчимэг-БСШУЯ-ны харъяа Мэргэжил арга зүйн төв 29 дүгээр тусгай сургуулийн сургалтын менежер

29. Пэрэнлэйн Пүрэв-Увс аймгийн Ус цаг уурын орчны шинжилгээний төвийн цаг уурын Улаангом өртөөний техникч

30. Рагчаабазарын Пүрэв-Сэлэнгэ аймгийн Газрын албаны улсын бүртгэгч

31. Наваанлхундэвийн Сандагдорж- Хэнтий аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дадлага хариуцсан багш

32. Дашдэндэвийн Сангаасүрэн- Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Хан-Өндөр импекс" ХХК-ийн гүйцэтгэх захирал

33. Тойсоны Сарантуяа- Нийслэлийн Аудитын газрын ахлах аудиторч

34. Наваантаяын Сүхбаяр-Дундговь аймгийн худалдаа үйлчилгээний "Батгарам" ХХК-ийн захирал

35.Лувсанчүлтэмийн Тунгалаг-Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Орос судлалын тэнхмийн багш

36. Дагвадоржийн Угтахбаяр-БСШУЯ-ны харъяа Мэргэжил арга зүйн төв 29 дүгээр тусгай сургуулийн бага ангийн багш

37. Пандийн Хишигсүрэн-Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын Кадастрын хэлтсийн мэргэжилтэн

38. Дампилын Хоролсүрэн-Нийслэлийн Баянгол дүүргийн 20 дугаар дунд сургуулийн монгол хэл,уран зохиолын багш

39. Баярын Цэвэгмэд - Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын агаар-сансар, дэвсгэр зургийн мэдээллийн сангийн эрхлэгч

40. Гуудайн Цэвэлмаа - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Ган зам" төвийн ахлах тогооч

41. Жамбалын Цэнд - "Монгол даатгал" компанийн Архангай аймаг дахь салбарын байцаагч

42. Жамъяншаравын Энхбат - Нийслэлийн худалдаа үйлчилгээний " Улсын их дэлгүүр" ХК-ийн ерөнхий жижүүр

43. Цагаачийн Энхбат - Нийслэлийн Багануур дүүргийн ЗДТГ-ын Цэргийн болон гамшгаас хамгаалах штабын дарга, хурандаа

44. Намсрайн Энхтуяа- Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Орос судлалын тэнхмийн багш

**ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Намжилын Баярсайхан-БХЯ-ны Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа

2. Дамбийбалжирын Жаргалсайхан-ЗХЖШ-ын Цэргийн удирдлага стратеги , төлөвлөлтийн газрын цэргийн удирдлагын ахлах мэргэжилтэн, хурандаа

3. Чойжамцын Хүрэлбаатар-ЗХЖШ-ын Ар талын газрын цэргийн зэвсэглэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа

4. Тэрбишийн Энхтөр- ЗХ-ний 189 дүгээр ангийн Захирагчийн 1 дүгээр орлогч штабын дарга, дэд хурандаа

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2004 оны 12 дугаар сарын 28-ны өдөр** **Дугаар 195** **Улаанбаатар хот**

### Жанцангийн Батчулуунд Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээх тухай

Эрчим хүчний салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж аймаг, сум, хот суурин газруудыг төвлөрсөн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох ажилд гүйцэтгэсэн хөдөлмөр зүтгэлийг нь үнэлж "Эрчим хүчний барилга угсралтын трест" ХК-ийн краны жолооч Жанцангийн Батчулуунд Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 2004 он №48 (381)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 1-ний өдөр | Дугаар 229 | Улаанбаатар хот

**Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2004 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний тодотгосон жагсаалтыг батлах тухай**

Монгол Улсын 2004 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн 2004 оны тодотгосон жагсаалт"-ыг 1 дүгээр хавсралт, "Улсын төсвийн хөрөнгө оруулалт, замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зам, гүүрийн барилга байгууламж, төсөл, арга хэмжээний 2004 оны тодотгосон жагсаалт"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батласугай.

2. Барилга байгууламж, төсөл, арга хэмжээг ашиглалтад оруулах хугацаа, тэргүүлэх ач холбогдол, эх үүсвэрийн батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлэх, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг төсвийн ерөнхийлэн захирагч нарт даалгасугай.

3. Төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлийн явц, ашиглалтад оруулах хугацаа, тэргүүлэх ач холбогдлыг харгалзан төсвийн ерөнхийлэн захирагчдын саналыг үндэслэн энэ тогтоолоор батлагдсан хөрөнгийн дүнд багтаан шаардлагатай бол зохицуулалт хийж ажиллахыг Сангийн сайд Н.Алтанхуягт зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2004 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлах тухай" Засгийн газрын 2004 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 84 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц. ЭЛБЭГДОРЖ

САНГИЙН САЙД Н.АЛТАНХУЯГ

*Засгийн газрын 2004 оны 229 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт*

**Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн 2004 оны тодотгосон жагсаалт**

Төсвийн эрх захирагчаар /сая.төг/

| дд | Төсөл, арга хэмжээний нэр, хүч чадал, байршил | Эхлэх, дуусах хугацаа | Төсөвт өртөг | Үүнээс: 2004 онд санхүүжүүлэх |
|---|---|---|---|---|
| А | Б | 1 | 2 | 3 |
| I | **Улсын Их Хурлын Тамгын Газрын Ерөнхий нарийн бичгийн дарга** | | **350.0** | **350.0** |
| 1 | УИХ-ын гишүүд болон Тамгын газрын ажилтнуудад орон сууц худалдан авах, Улаанбаатар | 2004-2004 | 250.0 | 250.0 |
| 2 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 100.0 | 100.0 |
| | **Үндэсний статистикийн газар** | | **40.0** | **40.0** |
| 1 | Интернетийн сүлжээнд холбох | 2004-2004 | 20.0 | 20.0 |
| 2 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 20.0 | 20.0 |
| | **Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс** | | **110.0** | **110.0** |
| 1 | Улс төрийн талаар хэлмэгдсэн иргэдэд олгох орон сууц | 2004-2004 | 100.0 | 100.0 |
| 2 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 10.0 | 10.0 |
| | **Үндсэн хуулийн цэц** | | **5.0** | **5.0** |
| 1 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 5.0 | 5.0 |
| II | **Монгол Улсын Ерөнхий сайд** | | **374.9** | **319.9** |
| II.1 | **Тагнуулын ерөнхий газар** | | **246.8** | **191.8** |
| 1 | Конторын барилга, 12 хүн, 2 машины гараж, Говь-Алтай | 2004-2005 | 120.0 | 65.0 |
| 2 | Их засвар | 2004-2004 | 26.8 | 26.8 |
| 3 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 100.0 | 100.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| II.2 | **Төрийн тусгай хамгаалалтын газар** | | **88.2** | **88.2** |
| 1 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 88.2 | 88.2 |
| II.3 | **МОНЦАМЭ** | | **29.9** | **29.9** |
| | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 29.9 | 29.9 |
| II.4 | **МРТХЭГ /"ММ" агентлаг/ тоног төхөөрөмж** | 2004-2004 | **10.0** | **10.0** |
| III | **Улсын мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд** | | **859.0** | **390.0** |
| | **Улсын мэргэжлийн хяналтын газар** | | **859.0** | **390.0** |
| 1 | Улсын мэргэжлийн хяналтын газрын байрны засвар, Улаанбаатар | 2003-2004 | 759.0 | 290 |
| 2 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 100.0 | 100.0 |
| IY | **Гамшгаас хамгаалах асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд** | | **43.0** | **43.0** |
| IY.1 | **Гамшгаас хамгаалах ерөнхий газар** | | **43.0** | **43.0** |
| 1 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 18.0 | 18.0 |
| 2 | Их засвар | 2004-2004 | 25.0 | 25.0 |
| Y | **Монгол Улсын сайд-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга** | | **1,057.0** | **1,057.0** |
| 1 | Төрийн мэдээллийн сүлжээний компьютер, техник тоног төхөөрөмж, программ хангамжийн шинэчлэлт | 2004-2004 | 100.0 | 100.0 |
| 2 | Удирдлагын академийн сонсогчдын дотуур байр, 112 хүн, Улаанбаатар | 2004-2004 | 250.0 | 250.0 |
| 3 | Их засвар | 2004-2004 | 533.4 | 533.4 |
| 4 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 141.6 | 141.6 |
| 5 | Сүмбэр сумын ЗДТГ-ын байрны өөрчлөлт, засвар | 2004-2004 | 32.0 | 32.0 |
| YI | **Гадаад хэргийн сайд** | | **296.0** | **296.0** |
| 1 | Астана хотод ЭСЯ-д байр худалдан авах | 2004-2004 | 40.0 | 40.0 |
| 2 | Их засвар | 2004-2004 | 143.0 | 143.0 |
| 3 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 113.0 | 113.0 |
| YII | **Сангийн сайд** | | **8,358.5** | **3,658.5** |
| YII.1 | **Сангийн яам** | | **120.0** | **120.0** |
| 1 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 25.0 | 25.0 |
| 2 | Их засвар | 2004-2004 | 95.0 | 95.0 |
| YII.2 | **Гаалийн ерөнхий газар** | | **7,438.5** | **3,438.5** |
| 1 | Гаалийн боомтын АТХШНЦогцолбор, Баян-Өлгий, Цагааннуур | 2002-2005 | 2850 | 987 |
| 2 | Гаальчдын орон сууц, 28 айл, Улаанбаатар | 2003-2005 | 700 | 378.8 |
| 3 | Шивээхүрэнгийн боомтыг нүүлгэн шилжүүлэх | 2004-2006 | 900 | 300 |
| 4 | Боомтуудын цахилгаан хангамжийг шинэчлэх, Арцсуурь, Бичигт, Ярант, Тэс, Ханги | 2004-2005 | 150 | 50 |
| 5 | Боомтуудын холбоожуулалт, Ярант, Булган, Ханги, Сайншанд, Хавирга | 2004-2005 | 77 | 27 |
| 6 | Боомтуудын усан хангамж, бохир усны систем, Арцсуурь, Боршоо, Бургастай, Ярант, Шивээхүрэн, Цагааннуур | 2004-2005 | 220 | 70 |
| 7 | Гаалийн хяналт, шалгалтын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл шинэчлэх | 2004-2005 | 430 | 180 |
| 8 | Олон улсын нисэх буудлын гаалийн салбарыг бэхжүүлэх, Ховд | 2004-2004 | 40 | 40 |
| 9 | Гаалийн конторын барилга, Дорнод, Эрээнцав | 2004-2005 | 50 | 38 |
| 10 | Боомтын барилга, Хөвсгөл, Ханх | 2004-2005 | 300 | 171.2 |
| 11 | Нохойн албыг бэхжүүлэх, Улаанбаатар | 2004-2005 | 50 | 25 |
| 12 | Гаалийн барилга байгууламжийн өргөтгөл, засвар шинэчлэлт | 2004-2004 | 211.5 | 211.5 |
| 13 | ШНЦ-ын агуулах, зам талбай, Замын -Үүд | 2003-2004 | 300 | 45 |
| 14 | Боомтын гаалийн ажилчдын байр, засвар, Бургастай | 2003-2004 | 30 | 25 |
| 15 | Боомтын зам, талбайн ажлын дуусгал, Гашуунсухайт | 2003-2004 | 300 | 200 |
| 16 | Боомтын зам, талбайн ажлын дуусгал, Бичигт | 2003-2004 | 150 | 80 |
| 17 | Гаалийн хорооны хяналтын талбай, гадна хашаа, Дорноговь | 2003-2004 | 100 | 30 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 18 | 100 т-ын электрон автопуу солих, Ханх, Арцсуурь, Боршоо, Ханги | 2004-2004 | 120 | 120 |
| 19 | Ажилчдын орон сууц, Горхийн амралт | 2004-2004 | 50 | 50 |
| 20 | Гаалийн албаны мэдээллийн автоматжуулсан системийн хүч чадлыг нэмэгдүүлэх, мэдээллийн сүлжээний өргөтгөл | 2004-2004 | 40 | 40 |
| 21 | Улсын орлогын барааны агуулах худалдаж авах, Улаанбаатар | 2004-2004 | 150 | 150 |
| 22 | Орон сууц 2 айл, Увс, Тэс | 2004-2004 | 40 | 40 |
| 23 | Орон сууц 8 айл, 2 машины гараж, агуулах, Бичигт,Сүхбаатар | 2004-2004 | 120 | 120 |
| 24 | Хяналтын талбай, гадна хашаа, Дорноговь, Ханги | 2004-2004 | 60 | 60 |
| **YII.3** | **YTEГазрын хөрөнгө оруулалт** | | **800.0** | **100.0** |
| 1 | Үндэсний татварын ерөнхий газрын конторын барилга, Улаанбаатар | 2004-2006 | 800.0 | 100.0 |
| **YIII** | **Хууль зүй, дотоод хэргийн сайд** | | **3,599.5** | **2,157.2** |
| **YIII.1** | **Яамны дүн** | | **71.0** | **71.0** |
| 1 | ХЗДХЯамны их засвар | 2004-2004 | 21.3 | 21.3 |
| 2 | ТТАХНЭмнэлгийн тоног төхөөрөмж | 2004-2004 | 27.0 | 27.0 |
| 3 | ХЗДХЯамны тоног төхөөрөмж | 2004-2004 | 22.7 | 22.7 |
| **YIII.2** | **Цагдаагийн ерөнхий газар** | | **748.0** | **648.0** |
| 1 | Эргүүл хамгаалалтын 801-р хорооны штаб сумангуудын байр | 2003-2004 | 400.0 | 300.0 |
| 2 | Цагдаагийн хэсгийн байр, 30 ш | 2004-2004 | 150.0 | 150.0 |
| 3 | Их засвар | 2004-2004 | 118.0 | 118.0 |
| 4 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 80.0 | 80.0 |
| **YIII.3** | **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар** | | **458.0** | **258.0** |
| 1 | Аймгуудад баривчлах байр, гадна хамгаалалтын хашаа барих | 2003-2004 | 223.0 | 113.0 |
| 2 | Хоригдлын хүчээр ашиглаж буй орд газруудын /шохойн чулуу, ногоон гантиг, тоосгоны шавар, нүүрс / хөрс хуулалт | 2002-2004 | 130.0 | 40.0 |
| 3 | Баривчлах байр, эмэгтэйчүүдийн хорих | 2004-2004 | 20.0 | 20.0 |
| 4 | Баривчлах байр, 457-р анги, Ховд | 2004-2004 | 20.0 | 20.0 |
| 5 | Тоосгоны үйлдвэр, 4 сая.ш. тоосго, 419-р анги, Хэнтий | 2004-2004 | 15.0 | 15.0 |
| 6 | Их засвар | 2004-2004 | 30.0 | 30.0 |
| 7 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 20.0 | 20.0 |
| **YIII.4** | **Хил хамгаалах ерөнхий газар** | | **2,245.5** | **1,103.2** |
| 1 | Хилийн 27-р отряд Дорнод, Мэнэн | 1999-2004 | 676.7 | 137.4 |
| 2 | Хилийн 0129-р ангийн штаб, цэргийн байр, Дорноговь, Эрдэнэ сум | 2002-2005 | 735.0 | 250.0 |
